

БАРАА НИЙЛҮҮЛЭХ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТЕНДЕЙН АШИГЛАЛТЫН ХУГАЦААНЫ ӨРТӨГ ТООЦОХ АРГАЧЛАЛ, ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ аргачлал, зааврыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /Шинэчилсэн найруулга/ хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх тендер үнэлэх үндсэн шалгуураар ашиглалтын хугацааны өртгийн шалгуурыг тогтоох, уг тендерийн ашиглалтын хугацааны өртгийг тооцоход дагаж мөрдөнө.

1.2. Ашиглалтын хугацааны өртгийн шалгуурыг тендер шалгаруулалтын баримт бичигт заах нь захиалагч зөвхөн анх худалдан авах үнэд суурилсан шийдвэр гаргах хувилбараас татгалзаж, бараа материал, хөрөнгийн нийт ашиглалт, төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаанд гарах бодит зардлыг тооцсоны үндсэн дээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах боломж бүрдүүлэх давуу талтай.

1.3. Захиалагч бүх бараа, үйлчилгээний хувьд ашиглалтын хугацааны өртгийг тооцох, зардлын мэдээллийг урьдчилан хөдөлбөргүйгээр тогтоох боломжгүй гэдгийг анхаарах шаардлагатай.

1.4. Захиалагч, түүний төсөв батлах эрх бүхий этгээд ашиглалтын хугацааны өртгийн үнэлгээний аргаар шалгарч, худалдан авах бараа, үйлчилгээний анхны худалдан авах зардал буюу гэрээний үнэ харьцангуй өндөр байх тохиолдолд ашиглалтын хугацааны өртгийг хэрэглэх шийдвэр гаргана.

Хоёр. Ашиглалтын хугацааны өртгийг тендер үнэлэх үндсэн шалгуураар тогтоох

2.1. Захиалагч хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4.2-т зааснаар ашиглалтын хугацааны өртгийг тендер үнэлэх үндсэн шалгуур байхаар тендер шалгаруулалтын баримт бичигт заахын өмнө тухайн бараа, үйлчилгээний ашиглалтын хугацааны өртгийг тооцох боломжтой эсэхийг урьдчилан нягтална.

2.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт ашиглалтын хугацааны өртөг тооцохоор заахад тухайн бараа, ажил, үйлчилгээний үр дүнд бий болох хөрөнгийг ашиглавал зохих ашиглалтын хугацааг заана.

2.3. Хөрөнгийн ашиглалтын хугацааг тооцоход ашиглах боломжтой бодит хугацааг тооцоолох шаардлагатай ба ийм бодит тооцоо, судалгаагүй тохиолдолд хууль тогтоомжид заасан элэгдэл, хорогдол тооцох хугацааг тооцож болно.

2.4. Үйлчилгээний хувьд ашиглалтын хугацааг гол төлөв гэрээний үргэлжлэх хугацааг тодорхойлох боломжтой байна.

2.5. Ашиглалтын хугацааны өртгийг энэ аргачлал, зааврын 2.2-т заасан хугацаанд гарах зардал нь анхны худалдан авах зардалтай харьцуулахад

харьцангуй их байх магадлалтай, техникийн тэгш бус санал ирэх магадлалтай гэж тооцсон бараа, ажил, үйлчилгээний хувьд хэрэглэх нь зохимжтой.

2.6. Бараа, үйлчилгээний үр дүнд хөрөнгийг захиалагчийн өмчлөл, эзэмшилд хүлээн авахтай холбоотой анхдагч зардлыг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.22-т заасан харьцуулах үнэ гэж тооцох ба ашиглалтын хугацаанд гарах дараах төрлийн зардлыг тендерийн үнэд багтсан байхаар шаардаагүй бол ашиглалтын хугацаанд гаргах зардлын төрөл байхаар тендер шалгаруулалтын баримт бичигт зааж болно:

2.6.1. өмчлөл, эзэмшилд хүлээн авах, угсралт суурилуулалт хийх, ашиглалтад хүлээлгэн өгөх зардал;

2.6.2. ашиглалтын хугацаан дахь үйл ажиллагааны зардал;

2.6.3. ашиглалтын хугацаан дахь материал, техник үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээний зардал;

2.6.4. ашиглалтаас гаргах болон устгах зардлууд.

2.7. Захиалагч бараа, үйлчилгээний шинж чанар, төвөгшилөөс шалтгаалж энэ аргачлал, зааврын 2.3-т заасан зардлын аль хэсгийг тооцохыг тендер шалгаруулалтын баримт бичигт заах ба жишээг 1 дүгээр хавсралтад заасан болно.

2.8. Ашиглалтын хугацаанд тооцох зардалд хөрөнгийн ердийн элэгдэл хорогдол, алдагдсан боломжийн өртгийг оруулах зэрэг аль нэг тендерийг сонгохтой холбоотойгоор өөрчлөгдөхгүй тогтмол байх зардлыг оруулахгүй.

2.9. Захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт дараах мэдээллийг тусгана:

2.9.1. Энэ аргачлал, зааврын 2.2-2.5-д зааснаар тогтоосон ашиглалтын хугацаа (жилээр);

2.9.2. Зардлуудын өнөөгийн цэвэр үнэ цэнийг тооцоход ашиглах хувиар илэрхийлсэн хямдруулалтын хувь;

2.9.3. Оролцогчийн тендертээ тусгах шаардлагатай зардлын мэдээлэл, техникийн үзүүлэлт, үйл ажиллагааны, засвар үйлчилгээний, үлдэх өртгийн зардлыг тооцоолоход ашиглах хүчин зүйлс болон аргачлал.

2.10. Энэ аргачлал, зааврын 2.9.2-т заасан хямдруулалтын хувь хэмжээг тогтооход Монголбанкны бодлогын хүүн дээр тодорхой хувь хувийг нэмж тооцож, тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана.

2.11. Монголбанкны бодлогын хүүн дээр нэмэх хүүгийн хэмжээг төсөл, арга хэмжээний эрсдэлд үндэслэн тогтооно.

Гурав. Ашиглалтын хугацаны өртөг тооцох

3.1. Захиалагч шаардлага нийцсэн тендер тус бүрийн дагуу нийлүүлэх хөрөнгийн ашиглалтын хугацаанд ирээдүйд гарах зардлыг өнөөгийн үнэ цэнээр илэрхийлж, 2 дугаар хавсралтын дагуу тооцно.

3.2. Тендерийн харьцуулах үнэ нь хуулийн 28 дугаар зүйлийн 28.7-д заасан гэрээний үнээс зөрүүтэй байх тохиолдолд харьцуулах үнийг гэрээний үнэ гэж

тооцож тусгана. Гэрээний дагуу төлбөрийг он дамжуулан төлөх тохиолдолд тендерийн харьцуулах үнийг төлбөр төлөх онуудад хувь тэнцүүлэн хуваана.

3.3. Шаардлагад нийцсэн тендерүүдийн ашиглалтын хугацааны өртөг тооцсон үнийг хуулийн 27 дугаар зүйлийн 27.5-д зааснаар өсөх дарааллаар эрэмбэлж, эхэнд эрэмбэлэгдсэн тендерийг хамгийн сайн тендер гэж үзнэ.

-о0о-

ТӨСӨД

АШИГЛАЛТЫН ХУГАЦААНД ГАРЧ БОЛОХ ЗАРДЛЫН ЖИШЭЭ

1. Захиалагч өмчлөл, эзэмшилд хүлээн авах, угсралт суурилуулалт хийх, ашиглалтад хүлээлгэн өгөхтэй холбоотой зардал:
 - Зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл;
 - Сургалт, хүний нөөц бэлтгэх;
 - Нийлүүлэлтийн цэгээс шилжүүлэх зардал;
 - Угсралт, суурилуулалт;
 - Бараа, үйлчилгээг ашиглахтай холбоотой нэмэлтээр авах зөвлөх үйлчилгээ, мэргэжилтний зардал;
 - Хууль зүйн баримт бичиг боловсруулах, бүртгэл хийлгэхтэй хууль, эрх зүйн үйлчилгээний зардал;
 - Одоогийн гүйцэтгэгч, нийлүүлэгчийг өөрчлөхтэй холбоотой дотоод шилжилтийн зардал (зардлыг тендер шалгаруулалт зарлахаас өмнө тооцсон байх).
2. Ашиглалтын хугацаан дахь үйл ажиллагааны зардал:
 - Ажиллах хүчний зардал
 - Засвар үйлчилгээ
 - Технологийн шинэчлэл, сайжруулалт
 - Түгээлт, ложистик
 - Аюулгүй байдал, хамгаалалт
 - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
 - Түүхий эд, материал өөрчлөхтэй холбоотой зардал
 - Тээвэр, шатахуун
 - Эрчим хүчний хэрэглээ, нийлүүлэлт
 - Ус, түүхий эдийн зарцуулалт
3. Ашиглалтын хугацаан дахь материал, техник үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээний зардал:
 - Даатгал, татвар
 - Гэрээний удирдлага, менежментийн төлбөр, хураамж
 - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, чанарын менежментийн зардал
 - Тайлагналт
 - Захиалга, төлбөр тооцоо
 - Сэлбэг хэрэгсэл, нэмэлт тоноглол
 - Үйлчилгээний болон хяналтын дэглэм, журам
 - Тоног төхөөрөмжийг ашиглаагүй хугацааны алдагдал
4. Ашиглалтаас гаргах болон устгах зардал:
 - Ашиглалтаас гаргах, буулгах, устгах зардал
 - Өгөгдөл шилжүүлэх, архивлах
 - Аюулгүй байдал, хамгаалалт
 - Хүний нөөц, ажиллах хүчний зардал
 - Дуудлага худалдаа хийх, зуучлагч ажиллуулах хөлс

- Үлдэх үүрэг хариуцлагыг шилжүүлэх
- Хөрөнгийн үлдэгдэл өртөг
- Газар, барилгыг өөр зориулалтаар ашиглахаар нөхөн сэргээх, засварлах зардал.

-оо-

ТӨСӨЛ

ЗАРДЛЫН ӨНӨӨГИЙН ҮНЭ ЦЭНИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ, ЖИШЭЭ

3.1. Жил бүр гарах зардлын өнөөгийн үнэ цэнийг тооцоход тухайн жилд хамаарах үржүүлэгч хувийг тооцож гаргана. Худалдан авах гэрээ байгуулах эхний жилийн үржүүлэгч хувь 1 байх ба дараагийн жилүүдийг дараах томъёоны дагуу тооцно.

$$\text{Үржүүлэгч хувь} = 1 / (1 + \text{хямдруулалтын хувь})^{\wedge\text{жил}}$$

Хямдруулалтын хувь = тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хувь
 \wedge жил = тухайн жилийн тоотой тэнцүү зэрэгт дэвшүүлнэ (жил 1 = 1, жил 2=2 гэх мэт)

Захиалагчаас 6 жилийн ашиглалтын хугацаатай, хямдруулалтын хувь 10% байх тохиолдолд хоёр өөр зардал бүхий тендерийн ашиглалтын хугацааны өртгөөр харьцуулах жишээг доор үзүүлэв.

2 дахь жилийн үржүүлэгч хувь тодорхойлох жишээ:

$$2 \text{ дахь жилийн үржүүлэгч хувь} = 1 / (1 + 0.1)^2 = 0.83$$

А тендерийн ашиглалтын хугацааны өртөг

Зардлын төрөл	Нийт (сая.төг)	Жил 0	Жил 1	Жил 2	Жил 3	Жил 4	Жил 5	Жил 6
Үржүүлэгч хувь		1.0	0.91	0.83	0.75	0.68	0.62	0.56
1 Захиалагч өмчлөл, эзэмшилд хүлээн авах зардал								
Гэрээний төлбөр	45	45						
Суурилуулалт (гэрээний үнэд ороогүй бол)	5	5						
2 Үйл ажиллагааны зардал								
Цахилгаан зарцуулалт	14	2	2	2	2	2	2	2
3 Засвар үйлчилгээний зардал								
Урсгал засвар	28	4	4	4	4	4	4	4
Төлөвлөгөөт засвар	6			6				
4 Ашиглалтаас гаргах, устгах зардал								
Шилжүүлэх зардал	10							10
5 Үлдэх өртгөөс орох орлого								
Хаягдал төмөр	(1)							(1)
НИЙТ	107	56	6	12	6	6	6	15
Өнөөгийн цэвэр үнэ цэн	92.12	56	5.46	9.96	4.5	4.08	3.72	8.4

Б тендерийн ашиглалтын хугацааны өртөг

Зардлын төрөл	Нийт (сая.төг)	Жил 0	Жил 1	Жил 2	Жил 3	Жил 4	Жил 5	Жил 6
Үржүүлэгч хувь		1.0	0.91	0.83	0.75	0.68	0.62	0.56
1 Захиалагч өмчлөл, эзэмшилд хүлээн авах зардал								
Гэрээний төлбөр	58	58						
Суурилуулалт (гэрээний үнэд ороогүй бол)	10	10						
2 Үйл ажиллагааны зардал								
Цахилгаан зарцуулалт	7	1	1	1	1	1	1	1
3 Засвар үйлчилгээний зардал								
Урсгал засвар	14	2	2	2	2	2	2	2
Төлөвлөгөөт засвар	3			3				
4 Ашиглалтаас гаргах, устгах зардал								
Шилжүүлэх зардал	5							5
5 Үлдэх өртгөөс орох орлого								
Хаягдал төмөр	(1)							(1)
НИЙТ	96	71	3	6	3	3	3	7
Өнөөгийн цэвэр үнэ цэн	88.78	71	2.73	4.98	2.25	2.04	1.86	3.92

Үлдэх өртгөөс олох орлогыг сөрөг утгаар тусгасан.

Дээрх хүснэгтийн дагуу А тендерийн анхны худалдан авах зардал Б тендерээс хямд боловч ашиглалтын хугацаанд гаргах зардлын хувьд Б тендер нь өртөг багатай байхаар байна.

-ооо-